

БАТЛАВ: "БАГАНУУР" ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Д. ТҮВШИНЖАРГАЛ

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Хийгдэх ажил нь дор дурдсан техникийн тодорхойлолтын дагуу байх ба эсхүл түүнтэй дүйцэхүйц байна.

Д/Д	Тоо ш	Хийгдэх ажлын нэр
1	2	Мод услах зориулалтаар цооног өрөмдүүлэх
2	2	Нийт

д / д	Скв №	Цооногийн гүн (м)	Өрөмдлөгийн эцсийн диаметр (мм)	Ус алдалтыг хаах бэхэлгээний яндан суулгах	Шүүртэй яндан суулгах		Тунгааг уурын урт (м)	Цооногийн зориулалт
					гүн (м)	голч (мм)		
1	1	120	159	Ус алдвал шавар болон бусад материалаар цооногийн ханыг бэхжүүлэх арга хэмжээ авах ба хэрэв зогсоож чадахгүйд хүрвэл бэхэлгээний яндан суулгаж зогсооно.	20	100	10	Нөхөн сэргээлт
2	2	150	159		40	100	10	Нөхөн сэргээлт

Тайлбар: Өрөмдөх цэгийн байршил, гүнийг геофизикийн хайгуулаар тогтоож гүйцэтгэлийг эцсийн нийт уртааш 270 метрээр тооцно. Гүний ус шүүрүүлэх цооногууд нь дараах бүтэцтэй байна: Ус татах насосны тэжээлийн кабель, ус өргөх хоолой, шит, бэхэлгээний тросс, усны гарцыг хэмжих тоолуураас бүрдэнэ. Тухайлбал цооногт суулгах насос иж бүрдлээрээ аль нэг нэрд гарсан фирмийнх байх ба өрөмдсөн цооногийн хувийн ундаргад тохирсон хүчин чадалтай байна.

Өрөмдлөгт тавигдах шаардлага, ажил гүйцэтгэх хугацаа

1. Техникийн тодорхойлолтод заасан өгөгдөл бүхий 2ш цооногийг өгөгдсөн

хугацаанд өрөмдөж чадах үзүүлэлттэй өрмийн тоног төхөөрөмж 1-ээс багагүй байна.


2. Гүйцэтгэгч нь захиалагчийн зааж өгсөн талбайд уст цэгийг тодорхойлж өрөмдлөгийн ажлыг явуулна.
3. Газрын гүн дэх хурдсууд (ан цавшил ихтэй нүүрс, элсэн чулуу, нүүрслэг аргиллит, алевролит)-д ус алдалт ихтэй байдаг учир шаардлагатай арга хэмжээ авахад бэлэн байх, уул геологийн хүндрэл гарвал хамгаалалтын яндан хэрэглэнэ.
4. Цооногийн гүнээс амсар хүртэл шүүртэй яндангийн араар 5-15 мм-ийн хайрга хийнэ.
5. Геофизикийн хайгуулаар тогтоосон цэгт гүний ус шүүрүүлэх цооног өрөмдөхөд ундрага нь 3л/сек-ээс багагүй байх. Ундарга нь хүрэхгүй тохиолдолд дахин өрөмдөнө.
6. 133 мм-ийн яндангийн холболт муфьтээр болон гагнуураар байж болно.
7. Ø133 мм-н голчтой дэвшилтэт технологи ашигласан зориулалтын шүүр хэрэглэнэ.
8. Цооногуудын угсралтын ажилд шаардагдах материал, тоног төхөөрөмжүүд нь стандартын шаардлага хангасан байна.
9. Цооногийн өрөмдлөгө, тоног төхөөрөмжийн угсралт, шавхалт туршилтын ажилд захиалагч талаас ТехноБХ хяналт тавина.
10. Цооногийн өрөмдлөг, тоног төхөөрөмжийн угсралтын ажлыг гүйцэтгэх технологи дараалал болон схемийг ирүүлэх.
11. 2 ш цооногийг хуанлийн 14 хоногийн хугацаанд өрөмдөж монтажлан захиалагчид хүлээлгэж өгнө.
12. Гэрээт ажлыг гүйцэтгэх хугацаанд ХАБЭА-тай холбоотой бүхий асуудлыг гүйцэтгэгч тал бүрэн хариуцна.
13. Ашиглалтанд хүлээлгэн өгөх цооног нь гадуураа хамгаалалтын битүүмжлэгдсэн төмөр хайрцагтай байна. Төмөр хайрцаг нь зөөвөрлөгдөх боломжгүй газарт суурилагдсан байна.

Гүйцэтгэх хугацаа : Гэрээ зурагдснаас хойш ажлын 7 хоногт багтаан эхлүүлнэ.

Гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан актыг (паспорт, каротаж) хээрийн ажил дууссанаас хойш 3 хоногийн дотор гаргаж өгнө.

Боловсруулсан: Гидрогеологч

Хянасан: ТехноБХ-ийн дарга



С. Алтангэрэл

Ч. Наранбат